

тухай бичиг баримт хэрэв хуулийн хучинтэй болсон бол тэдгээрийг хулээн ,зөвшөөрч гуйцэтгэх болыо.

Жаран дөрөвдугээр зуйл

Шуухийн зардлыг төлөх тухай шийд-  
вэрийг гуйцэтгэх

1. Энэхуу Гэрээний 2-р зуйлд зааснаар шуухийн зардал хангахаас чөлөөлөгдсөн, шуух ажиллагаанд оролцогч этгээдэд хуулийн хучин төгөлдөр болсон Хэлэлиэн Тохирогч нэг Этгээдийн шуухийн шийдвэрээр шуухийн зардал төлөх уурэг оногдуулвал, энэхуу шийлвэрийг зохих Этгээдийн хусэлтийн дагуу Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт татвар толүүлэлгуйгээр албадан гуйцэтгуулнэ.

2. Энэ зуйлийн I дэх ангийн зааснаар шийдвэрийг албадан гуйцэтгуулэх тухай хусэлтийг хэрэгжуулэгч шуух нь шуухийн зардал төлуулэх тухай шийдвэр хуулийн хучин төгөлдөр болсон эсэх, туунийг гуйцэтгэх эсэхийг зөвхөн тогтоох төдийгөөр хязгаарлана.

3. Албадан гуйцэтгуулэх шийлвэрийг хэрэгжуулэх тухай хусэлт туунд хавсаргасан бичиг баримтын хувьд энэхуу Гэрээний 6I-р зуйлийн заалтыг хэрэглэнэ.

Жаран тавдугаар зуйл

Эд хөрөнгийг авч тарах ба мөнгө  
гуйвуулах

iii шуухийн шийдвэрийн дагуу эд хөрөнгийг авч тарах, мөнгө гуйвуулах тухай Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн хууль тогтоомжинд энэхуу Гэрээний шуухийн шийдвэрийг албадан гуйцэтгуулэх тухай заалтууд хамаарагдахгуй.